



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ДЭЛГЭР СУМЫН МАНЫН
ХОРООНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРӨЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

/2020-2024 ОН/

АЛТАЙ ХОТ

2020 ОН



8217144139
ДЮА0060 9018301

Говь-Алтай Дэлгэр сумын МАНЫН хорооны
2020 оны 06 сарын 15-ны өдрийн
дугаар тогтоолын хавсралт



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ДЭЛГЭР СУМЫН МАНЫН ОРОН НУТГИЙН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ “ДЭЛГЭР НУТГАА ХАМТДАА ХӨГЖҮҮЛЬЕ” МӨРИЙН
ХӨТӨЛБӨР /2020-2024/**

АГУУЛГА

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ- НИЙГМИЙН ДЭВШИЛ

1. Эрүүл мэндийн бодлого
2. Боловсрол, биеийн тамирын бодлого
3. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн дэмжих бодлого

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ- АЖЛЫН БАЙР

1. Мал аж ахуйг эрчимжүүлэх
2. Газар тариалан эрхлэлтийг нэмэгдүүлэх
3. Бизнес эрхлэлтийг дэмжих
4. Ажлын байрыг нэмэгдүүлэх
5. Эрчим хүчний өргөтгөл

ГУРАВ. ДЭД БҮТЭЦ- ҮЙЛДВЭРЖҮҮЛЭЛТ

1. Эрчим хүчний өргөтгөл, шинэчлэл
2. Зам, тээвэр, үйлдвэржилтийн бүтээн байгуулалт
3. Хот байгуулалт, барилга орон сууцны хөгжил
4. Мэдээлэл, харилцааны холбооны дэвшил

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН- АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

1. Ногоон байгууламж
2. Орон нутгийн, онцлогт тохирсон аялал жуучлал байгаль хамгаалал
3. Бичил уурхан иргэдийн оролцоо
4. Улс болон орон нутгийн тусгай хамгаалалтыг нэмэгдүүлнэ
5. Цөлжилт, элсний нүүдлээс хамгаалах, ногоон байгууламж

ТАВ. ИРГЭДИЙН ОРОЛЦОО- ЗӨВ ЗАСАГЛАЛ

1. Эрх мэдэлтнийг биш, эрх зүйт төрийг дээдэлнэ
2. Түмэндээ ойртсон төрийн үйлчилгээ
3. Авилга, хүнд суртал, чирэгдэлгүй зөв засаглал
4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах
5. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ДЭЛГЭР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРООНООС ОРОН НУТГИЙН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ “ДЭЛГЭР
НУТГАА ХАМТДАА ХӨГЖҮҮЛЬЕ” МӨРИЙН ХӨТӨЛБӨР

/2020-2024/

МУ-ын Засгийн газрын болон аймгийн Монгол Ардын Намаас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрүүдийг дэмжин ажиллахын зэрэгцээ Дэлгэрчүүдийн санаа бодолд тулгуурлан холбогдох хууль тогтоомжинд нийцүүлэх энэхүү хөтөлбөрийг боловсруулан сонгоч олондоо өргөн барьж байна.

**НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ-НИЙГМИЙН ДЭВШИЛ- БОЛОВСРОЛ, БИЕИЙН
ТАМИРЫН БОДЛОГО**


Мэргэжлийн чадварлаг боловсон хүчинээр бүрэн хангагдсан, эрүүл мэнд, боловсрол, соёл, халамжийн үйлчилгээг чанаржуулж хүртээмж үр өгөөжийг нэмэгдүүлэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар иргэн бүрийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГО


- 1.1.1 Орон нутгийн эмч, эмнэлийн ажилтануудыг хүрэлцээ хангамж ур чадварыг сайжруулан эмчилгээ оношилгооны шинэ дэвшилтэт арга барил эзэмшүүлж, нэвтрүүлэх зэрэг асуудлыг үе шаттай шийдвэрлэнэ
- 1.1.2 Эрүүл мэндийн явуулын үзлэг оношлогоонд багт жил бүр зохион байгуулна.
- 1.1.3 Ахмадууд, ХБИргэдийн үзлэг оношлогоонд хамруулж, эмчилгээ сувилгаанд тогтмол хамруулна.
- 1.1.4 Эхийн эндэгдлийг гаргахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, хүүхдийн эндэгдлийг бууруулна
- 1.1.5 Ахмадуудын эмнэлгийн үзлэг оношлогоонд хамруулж, эмчилгээ сувилгаанд тогтмол хамааруулна.
- 1.1.6 Эмнэлгийн удирдлагын чадавхийг дээшлүүлж, сүүлий үеийн техник, тоног төхөөрөмжүүдийг нэвтрүүлэх замаар эмнэлгийн чанар хүртээмжийг сайжруулна.

1.2 БОЛОВСРОЛ, БИЕИЙН ТАМИРЫН БОДЛОГО

- 1.2.1 Хүүхэд залуучуудыг өвлийн спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлнэ.



- 1.2.2 Хөдөөгийн хүүхэд, залуучуудыг биеийн тамир, спортоор хичээллэх боломж нөхцөлийг бүрдүүлж, хуучин спорт заалыг засварлах ажлыг үе шаттай зохион байгуулна
 - 1.2.3 Боловсрол соёлын салбарыг чадварлаг боловсон хүчинээр тасралтгүй хангадах боломжийг бий болгож, удирдах ажилтны ур чадвар арга барилыг дээшлүүлэх, өндөр мэргэшилтэй багш соёлын ажилтануудыг орон нутагт тогтворт суурьшилтай ажиллах таатай орчныг бүрдүүлнэ.
 - 1.2.4 Боловсрол соёлын салбар дахь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бүхий л талаар дэмжиж, хувиараа нэмэлт болон гүнзгийрүүлсэн судлах сургалтын орчинг бүрдүүлнэ.
 - 1.2.5 Сумын төвийн цэцэрлэг, сургуулийн шинэ барилгыг төвлөрсөн халуун, хүйтэн, цэвэр бохирын шугамд холбоно.
 - 1.2.6 Хүүхэд залуучуудын амралт чөлөөт цагийн талбайг засварлан өргөтгөж, тоглоом тоног төхөөрөмжөөр бүрэн хангана
- 1.3 НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО
- 1.3.1 Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэг, эмзэг бүлгийн иргэд хүртээмжтэй болгож, нийгмийн даатгалд хамрагдах хүрээг нэмэгдүүлж, тэтгэврийн суурь даатгалын тогтолцоонд сумын хүн амын хамралтыг нэмэгдүүлнэ.
 - 1.3.2 Эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй уялдуулан ажлын байрыг тууштай нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг багасган, өрхийн амжиргааг дээшлүүлнэ.
 - 1.3.3 Ажлын байр шинээр бий болгож буй аж ахуйн нэгж, байгууллагыг бүх түвшинд орон нутгийн бодлогоор дэмжинэ
 - 1.3.4 Байгаль орчныг хамгаалах, бүтээн байгуулалт, нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн тохижилт үйлчилгээний ажилд амжиргааны баталгаажих түвшингээс доогур орлоготой иргэдийг өргөнөөр татан оролцуулах замаар өрхийн орлогын нэмэгдүүлнэ.
 - 1.3.5 Малчдын нийгмийн хамгаалалын эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар шинэ санаачилга гаргаж, залуу малчдыг бүх талаар дэмжинэ.



8217144139
ОУДООД 9018501

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ- АЖЛЫН БАЙР

Эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, хөгжилд чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэн үр ашгийг нь нэмэгдүүлж, ажлын байр бий болгон ард иргэдийн өрхийг орлогыг нэмэгдүүлнэ.

2.1. МАЛ АЖ АХУЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ

2.1.1 Мал сүргийг эрүүлжүүлэх арга хэмжээг тууштай хэрэгжүүлж, халдварт празит өвчинтэй тэмцэх ажлыг тогтсон хугацаанд явуулж эрүүл бүсийн статусаа хадгалж галзуу, бруцеллоз зэрэг халдварт өвчний гаралтыг бууруулна.

2.1.2 Орон нутгийн эдийн засгийг тэлэх бодлогыг баримталж, байгууллага аж ахуйн нэгжийг санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, айл өрх, иргэд, худалдаа эрхлэгчдийн орлогын өсгөхөд шаардагдах орон нутгийн шийдвэрүүдийг богино хугацаанд гаргаж ажиллана.

2.1.3 Малжуулах аяанг үргэлжлүүлэн, мал аж ахуйн үйлдвэрлэлд тогтвортой ажиллаж байгаа цөөн малтай малчин өрхийг эхний ээлжинд хамруулах арга хэмжээг авна.

2.1.4 Сумын өвс тэжээлийн нөөцийг өргөтгөн, аюулгүй нөөцийн санг бүрдүүлэн мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулна.

2.1.5 Жил бүр 2-оос доошгүй инженерийн хийцтэй болон энгийн уурхайн худаг шинээр гаргаж, худаг уст цэгийг засварлан бэлчээр усжуулах ажлыг дэс дараатай зохион байгуулна.

2.1.6 Бэлчээрийг улирлын хуваарийн дагуу ашиглах, өнжөөх сэргээх, хашиж хамгаалах зэрэг арга хэмжээг тууштай хэрэгжүүлж, хортон мэрэгчтэй тэмцэх аргыг нэвтрүүлж, үр дүнг дээшлүүлнэ


2.1.7 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдийн хоршоодын үйл ажиллагааг эрчимжүүлэн дэмжиж, биржийн арилжаанд оролцох эрхтэй иргэд, аж ахуйн нэгжүүдийг бий болгоно.

2.1.8 Мал экспортлох байрлалын давуу боломжоо ашиглан сум дундын стандартын шаардлага хангасан нядалгааны цехийг бийг болгох асуудлыг бодлогоор дэмжинэ.

2.2. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

2.2.1 Сумын хэмжээнд тогтоогдсон усалгаатай тариалан эрхлэх боломжтой газруудыг эргэлтэнд оруулах зорилт тавьж, төмс хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангах бодлого хэрэгжүүлнэ.

2.2.2 Гуулин тосгонд услалтын системүүдийг түшиглэн тэжээлийн ургамал тариалж, гурил болон тэжээлийн бага оврын үйлдвэр байгуулна.



2.2.5 Сумын хилийн цэсийг тодотгон өвөлжөө бууц, бэлчээр уст цэгийн маргааныг шийдвэрлэнэ

2.3. БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ

2.3.1. Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчинг бүрдүүлж, төрийн байгууллагын хууль бус дарамт шахалтыг арилгана

2.3.2. Жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг төсөл хөтөлбөрүүдэд хамруурлан, ажлын үр өгөөж хүртээмжийг дээшлүүлнэ.

2.3.3. Хувийн хөрөнгө оруулалтыг эдийн засгийн бодит салбаррт оруулах нөхцөл боломжийг дэмжиж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

2.3.4. Баялаг бүтээгчдийн борлуулалтыг дэмжин иргэд худалдан авагчдын эрэлт хэрэгцээг хангасан “Дэлгэрийн намар” үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулж үндэсний үйлдвэрлэгчдийг хамруулж ажиллана.

2.3.5 Төсөл хөтөлбөрт өрх бүрийг жигд хамрагдах боломжийг бүрдүүлнэ.

2.4 АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛНЭ

2.4.1 Ажилгүй, амжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд мэргэжил олгох сургалт зохион байгуулж, бүлэгт хамруулан ажлын байртай болгоход нь дэмжлэг үзүүлж ажиллана.

2.4.2 Сумын төвийн шинэчлэл төслийг ажлыг эрчимжүүлж хариуцлагтай, мэргэжлийн байгууллага, иргэдийн оролцоотой хяналтан дор хэрэгжүүлж ашиглалтанд оруулна

2.4.3 Шинээр сургууль төгссөн мэргэжилтэй чадварлаг боловсон хүчинүүдийг бодлогоор дэмжин ажлын байраар ханган ажиллана.

2.5 ЭРЧИМ ХҮЧНИЙ ӨРГӨТГӨЛ

2.5.1 Гуулин Дэлгэрийг холбосон 10 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг 35 кв болгон өргөтгөж, сумын цахилгаан эрчим хүчиний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.5.2 Хөв булгийн нүүрсний уурхайн ашиглалтыг сайжруулж, нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, орон нутаг руу чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж улмаар сумын иргэдэд хөнгөлөлт эдлэх боломжийг олгоно,

2.5.3 Шөнийн тарифт тоолуур суурилуулах ажлыг эхлүүлнэ



ДӨРӨВ. ЗАМ, ТЭЭВЭР, ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

3.1 Говь-Алтай аймгийн Дэлгэр сумаас Баянхонгор чиглэлийн 126.3 км авто замын ажил ашиглалтанд орохтой холбогдуулан шинээр үүсэх сууршлын бүсийн төлөвлөлтийг хийн сүм орон нутгийн иргэд ААН-үүдэд бизнесийн таатай нөхцөл бүрдүүлж ажлын байрыг хадгалж ажиллана.

3.3.2 Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан сумын төвийг засмал замтай холбон авто зам гэрэлтүүлэн, замын тэмдэглэгээг хийж гүйцэтгэнэ. Мөн Хөв булгийн нүүрсний уурхайг улсын чанартай төв зам дагуу сайжруулсан замаар холбоно.

3.3.3 Хунчир, артишок, чихэр өвс тариалалтыг нэмэгдүүлж, эмийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлыг судална

3.3.4 Нэг сүм- нэг үйлдвэр хөдөлгөөнийг улам эрчимжүүлж, иргэдийн орлого ашгийг нэмэгдүүлнэ.

3.4 БАРИЛГА ОРОН СУУЦНЫ ХӨГЖИЛ

3.4.1 Тайгам тосгонд 20 айлын орон сууц барьж ашиглалтанд оруулан, сумын ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ

3.4.2 Гэр хорооллыг орон сууцны анхан шатны дэд бүтэц буюу цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбож, иргэдийг амины орон сууцтай болгох нөхцөлөөр хангана.

3.4.3 Баян-Өндөр багийн гуанзны үйлчилгээ эрхлэгч айл өрхийн шинээр суурьшлын төвийн төлөвлөлтийг хийн нүүлгэн шилжүүлэлтийг шийднэ.

3.5 МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА ХОЛБОО ДЭВШИЛ

3.5.1 Суманд холбооны шилэн кабель шинээр татаж, харилцаа холбооны үйлчилгээг шинэ шатанд гарган, интернэтийн цахим үйлчилгээг ард иргэйн хүртээл болгоно.


3.5.2 Жи- мобайл болон үүрэн телефоны хамрах сүлжээг сайруулна

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН- АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

4.1 БАЙГАЛЬ ХАМГААЛАХ

4.1.1 Гуулинд мод үржүүлгийг талбайг нэмэх замаар таримал ойн талбайг одоогийн түвшингээс нэмэгдүүлнэ

4.1.2 Тайгам болон Гуулин тосгоны төвүүдийг ногоон байгууламжийн усалгаа, арчилгааг бүрэн шийдвэрлэнэ.



4.1.3 Байгууллага, аж ахуйн нэгж бүрийг хуулийн дагуу ойжуулах, цэцэрлэгжүүлэх ажилд дайчлан оролцуулах замаар “НОГООН ТОСГОН” “НОГООН БАЙГУУЛЛАГА” “НОГООН ХАШАА” бий болгоно

4.3 БИЧИЛ УУРХАЙН ИРГЭДИЙН ОРОЛЦОО

4.3.1 Хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн тайланг гаргуулан, дүгнэлт хийж, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжиж ажиллана

4.3.2 Нөхөн сэргээлт нэрийн доор ашигт малтмал олборлодог гадны компаниудын үйл ажиллагааг таслан зогсооно

4.4 УЛС БОЛОН ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАГААЛАЛЛЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.

4.4.1 Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэх, аймаг, сумын тусгай хамгаалалттай газар нутгийг шинэчлэн баталгаажуулалх, ховор амьтан ургамал, түүх соёлын газрын хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авна

4.4.2 Орон нутаг дахь уул уурхайн үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд явуулах хяналтыг сайжруулж, хамтын ажиллагааг өргөжүүлнэ


4.4.3 Байгаль орчны хуулийн дагуу иргэн бүр мэдээлэгч- хамгаалагч байх тогтолцоог бүрдүүлэн, урамшууллын систем тогтох хэрэгжүүлнэ.

4.4.4 Мэргэжлийн чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран усны нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлжр, булаг, шанд, уст цэгийн тоог нэмэгдүүлэх, хамгаалах ажлыг тогтмол зохион байгуулна

4.5 НОГООН БАЙГУУЛАМЖ

4.5.1 Усны харуулын тоог нэмэгдүүлж, үүлэнд зориуд нөлөөлөх, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран явуулна

4.5.2 Үерийн уснаас хөрсний эвдрэлийг хамгаалан, үерийн усыг хуримтлуулан усалгаанд ашиглах хөв, цөөрмийг 1-ээс доошгүйг улс орон нутгийн төсөв төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр барьж байгуулна



Ажлын салбарын төслийн төвийн албаны шаардлага бүрэн хангаж нээлттэй шалгаруулалтад шалгарсан хүнийг төрийн албанад томилдог зарчмыг бүрэн хэрэгжүүлнэ.


- 5.1.2 Даргын хууль бус шийдвэрийг биш хуулиа хэрэгжүүлдэг болно
- 5.1.3 Төрийн албан хаагчдыг сонгуулийн үр дүнгээр намын харьяалалаар хууль бусаар халж, сольж, албан тушаал бууруулж, албан тушаалд дэвшүүлж томилдог буруу зуршлыг эцэс болгоно
- 5.1.4 Иргэдийг Төлөөлөгчдийн Хурал, багийн Иргэдийн нийтийн хуралд зөвшилцлийн зарчмыг тууштай баримталж, цөөнхийг хүндэтгэж, оновчтой санал, санаачилгыг нь дэмжиж ажиллана

5.2 ТҮМЭНДЭЭ ОЙРТСОН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- 5.2.1 Тулгамдсан, нэн шаардлагатай зорилтуудыг олж тодорхойлох, тэддгээрийг шийдвэрт тусгаж хэрэгжүүлэхийн тулд бүх шатны Иргэдий Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн үйл ажиллагааг тогтмолжуулж, шаардлагатай асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулдаг болно.
- 5.2.2 Хөдөөгийн багуудын ажлын нөхцөлийг сайжруулж, багий дарга, эмч нарыг багийн төв дээр тогтмол ажиллуулах боломжийг бүрдүүлнэ. Гуулин тосгоны Захирагчийн ажлын албаны барилгыг шинээр барьж ашиглалтанд оруулна.

5.3 АВИЛГА, ХҮНД СУРТАЛ, ЧИРЭГДЭЛГҮЙ ЗӨВ ЗАСАГЛАЛ

- 5.3.1 Төрийн байгууллагуудын хүнд сурталгүй зарчимч, шуурхай, ил тод, нээлттэй байдлыг хангана. Үүний тулд нэг цэгийн үйлчилгээ, шилэн данс төрийн албаны бусад цахим үйлчилгээний нэр төрийг нэмэгдүүлж, хүрээг өргөтгөнө
- 5.3.2 Төрийн нууцад хамаарахаас бусад мэдээлэлтэй иргэд тогтмол танилцаж байх боломжоор хангана.
- 5.3.3 Иргэд аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд саа учруулж байгаа элдэв зөвшөөрөл, хязгаарлалтыг багасгаж, нийтийн эрх ашгийг хамгаалсан, зайлшгүй байх заавар, журмуудыг боловсруулж хэрэгжүүлнэ




5.3.4 Төрийн захиргааны болон төрий үйлчилгээний байгууллагуудын хүнд суртлыг арилган, иргэдэд чирэгдэлгүй хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилготой ажиллуулна

5.4 ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

5.4.1 Төв суурин газрыг бүрэн камержуулан гэрэлтүүлэгийг сайжруулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орчныг бүрдүүлнэ

5.4.2 Олон нийтийн эргүүл, малын хулгайтай тэмцэх малчдын бүлэг нөхөрлөл, нийтийг хамарсан хэв журмын ажлуудыг сэргээн идэвхжүүлнэ.



ДЭЛГЭР СҮМЫН МОНГОЛ АРДЫН
НАМЫН ХОРОО

